Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлан,
Эрүүл мэндийн яам, 2026 оны 3 дугаар улирлын байдлаар

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ				
	22		8.5. Энэ хуулийн 8.1.24, 19.3.3-т заасан үйл ажиллагааг зохион байгуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Эрүүл мэндийн сайдын 2025.11.20-ны өдрийн А/437 дугаар тушаалаар урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны багц, товлолыг шинэчлэн, боловсруулах ажлын хэсэг байгуулагдан, журмын төслийг боловсруулсан. Журмын төсөлд ургийн эрт илрүүлэг, нярайн эрт илрүүлэг, сургуульд суурилсан эрт илрүүлэг, Ажлын байран дахь эрт илрүүлэг, хавдрын эрт илрүүлэг (Ходоод, улаан хоолойн хорт хавдрын эрт илрүүлэг, Элэгний хорт хавдар хавдрын эрт илрүүлэг, Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэг, Уушгины хорт хавдрын эрт илрүүлэг, Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг) гэсэн ангиллаар тусгасан ба зорилтот насны бүлгийн багцын дагуу урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдах багцын зураглал гаргаж, ургийн багц; 0-28 хоногтой нярайн багц; 6, 12, 15, 17, 18-39, 40-49 насны багц; 50-иас дээш насны багц гэж тодорхойлсон. Цаашид урьдчилан сэргийлэх, скрининг болон эрт илрүүлэг үзлэгийг дараах үндсэн чиглэлээр зохион байгуулахаар төлөвлөж байна. Үүнд: 1. Зорилтот хүн амд хийгдэх илрүүлэг /скрининг/, эрт илрүүлэг үзлэг (ургийн илрүүлэг, нярайн цогц илрүүлэг, сургуульд суурилсан эрт илрүүлэг (6, 11, 15 насанд), халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг, зонхилон тохиолдох хорт хавдрын эрт илрүүлэг); 2. Хүн амын бүлэг, хэрэгцээнд суурилсан урьдчилан сэргийлэх үзлэг. Эрүүл мэндийн сайдын 2026 оны А/20 дугаар тушаалаар "Нярайн цогц скрининг шинжилгээ хийх заавар"-ыг шинэчлэн батлаж, 26 төрлийн эмгэгийг эрт нярай үед илрүүлэх, оношлох, эмчлэх боломж бүрдсэн. ЭМЯ-ны Нярайн цогц скринингийн үндэсний баг 2026 оны эхний хагас жилд 4 төрлийн чиглэлээр 31,534 нярайд скрининг хийснээс дотоод шүүрэл, бодисын солилцооны скринингийг 3,015 нярайд буюу нийт нярайн 13.94%-д, пульсоксиметрийн скринингийг 17,343 буюу нийт нярайн 80%-д,

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
				нүдний угийн улаан рефлексийн скринингийг 11,176 буюу нийт нярайн 51.6%-д, түнхний ЭХО скрининг 19,468 буюу нийт нярайд 90.1%-д хийсэн байна. Нярайн скринингийн хамрагдалтын хувь 4 төрлийн скринингээр дундажаар 58.8% байна. Үүгээр 4,752 нярай скрининг шинжилгээгээр эмгэгтэй болох нь тогтоогдож, эмчилгээ, эрт үеийн арга хэмжээг зөв авснаар хөгжлийн бэрхшээл, эндэгдэлд хүрэхээс сэргийлсэн. Хувь 58.8 байна. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчинд хүргэж болзошгүй ажлын байрны нөхцөлд ажилладаг ажилтны эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийг зохион байгуулах, хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах “Ажилтны эрүүл мэндийн үзлэгийн журам”-ыг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2026.03.04-ний өдрийн А/79 дүгээр тушаалаар батлуулсан. Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлэх хүрээнд тушаалд өөрчлөлт оруулах шаардлага гарсан. “Жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага, жолоочийн эрүүл мэндийн үзлэг явуулах журам батлах болон эрүүл мэндийн тодорхойлолт” зэрэг бусад холбогдох тушаал, шийдвэрийн хүрээнд хэрэгжих урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо багтана. Эрүүл мэндийн тухай хуулийн 19.3.3-т заасан үйл ажиллагаа (эм, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх)-г зохион байгуулах зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/100 дугаар тушаалаар "Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгчийн баримт бичигт тавигдах шаардлага"-ыг баталж мөрдөж байсныг Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь заалтад “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэснийг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/40 дүгээр тушаалаар хүчингүй болгосон ба дээрх үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу зохицуулж байна. Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17-д заасны дагуу тус журмыг батлах боломжгүй. УИХ-д хэлэлцүүлэхээр бэлтгэж буй Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийг дагалдан өөрчлөгдөх Эрүүл мэндийн тухай хуулийн

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
				төслийн өөрчлөлтөд энэ заалтыг өөрчлүүлэх саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн.
	28		41.3. Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг бүртгэх үйл ажиллагаатай холбоотой хэрэгцээний үнэлгээ хийх, мэргэжлийн үйл ажиллагааны төслийг үнэлэх болон хэрэгцээний тодорхойлолт гаргах шинжээч сонгон шалгаруулах, томилох, шинжээчийн ажиллах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хэрэгцээний тодорхойлолт олгохтой холбоотой үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишиг, шинжээчид олгох зардлын жишгийг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	Эрүүл мэндийн сайдын 2024.02.20-ны өдрийн А/74 дүгээр тушаалаар “Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх журам”-ыг шинэчлэн баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2024.05.17-ны өдрийн 6814 дугаарт бүртгүүлсэн. Журмын дагуу ЭЭХХЗГ 2026 оны 3 дугаар улирлын байдлаар Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх 86 бодисын улсын бүртгэлд сунгалт хийсэн. “Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг бүртгэх үйл ажиллагаатай холбоотой хэрэгцээний тодорхойлолт гаргах шинжээч сонгон шалгаруулах, томилох, шинжээчийн ажиллах журам, хэрэгцээний тодорхойлолт олгохтой холбоотой үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишиг, шинжээчид олгох зардлын жишиг”-ийн төслийг боловсруулж, саналыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас авсан байна.
16	40	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль 2023-06-16 Дугаар 2023.06.16	36.4. Энэ хуулийн 36.1.2-т заасны дагуу худалдан авах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.	“Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах журам"-ыг Засгийн газрын 2024 оны 42 дугаар тогтоолоор баталсан. “Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллага, эмийн зохицуулалтын үнэлгээгээр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагатай гадаад улсаас шууд болон дамжуулан худалдан авах журам”-ын төсөлд яамдаас ирүүлсэн саналыг тусгаж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 1/2109 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Тус тогтоолын дагуу цусны бүлэгнэлтийн эмгэг (гемофили)-ийн эмчилгээнд улсын хэмжээнд хэрэглэх гемофиллийн VIII, IX дүгээр факторыг 2026 онд батлагдсан 2.7 тэрбум төгрөгөөр худалдан авч Цус сэлбэлт судлалын үндэсний төвд 2026.09.01-ний өдөр

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
				нийлүүлсэн. Үүний дүнд нэгжийн үнэ буурч, хэмнэлт 350.0 сая төгрөгийн төсвөөр 3 нэр төрлийг нэмэгдүүлж, худалдан авалт хийсэн.
	55		23.10. Эмийн эмнэлзүйн туршилтын үе шат, тавигдах шаардлага, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага, гэрээний загвар, хяналт тавих журам, лабораторийн оношилгооны хэрэгслийн туршилт судалгаа хийх журмыг эрүүл мэндийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.	“Эмийн эмнэлзүйн туршилтын үе шат, тавигдах шаардлага, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага, гэрээний загвар, хяналт тавих журам, лабораторийн оношилгооны хэрэгслийн туршилт судалгаа хийх журам” боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/146 дугаар тушаалаар байгуулсан. Олон улсын зааврыг орчуулж, эмийн эмнэлзүйн туршилтын үе шат, тавигдах шаардлага, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага, гэрээний загвар, хяналт тавих журмын төслийг боловсруулж, санал авахаар яамны цахим хуудаст байршуулсан https://moh.gov.mn/news/7510. Лабораторийн оношилгооны хэрэгслийн туршилт судалгааны олон улсын стандартыг орчуулж, хянаж, стандартын төслийг боловсруулж байна.
	60		47.6. Гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллага, эмийн зохицуулалтын үнэлгээгээр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагатай гадаад улсаас шууд болон дамжуулан худалдан авах эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн, биобэлдмэл, вакцины санхүүжилтийг зохицуулах журмыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	“Гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллага, эмийн зохицуулалтын үнэлгээгээр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагатай гадаад улсаас шууд болон дамжуулан худалдан авах эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн, биобэлдмэл, вакцины санхүүжилтийг зохицуулах журам”-ыг боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/101 дүгээр тушаалаар байгуулж, журмын төсөл боловсруулж байна.
	61		47.8. Энэ хуулийн 47.7-д заасан саналыг үндэслэн зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн бөөний болон жижиглэнгийн үнийн нэмэгдэх хувь хэмжээний дээд хязгаарыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/429 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн бөөний болон жижиглэнгийн үнийн нэмэгдэх хувь хэмжээний дээд хязгаар”-ын төслийг боловсруулж, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, мэргэжлийн холбоодоос санал авахаар 2026.03.03-ны өдрийн 9/914 дугаар албан бичиг хүргүүлж, санал авсан. Төслийг ЭЭХХЗГ-ын цахим хуудсанд https://mmra.gov.mn/?id=201965 байршуулан санал авч, төслийг боловсронгуй болгож байна.

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
				Журмын төслийг 2026.03.31, 2026.04.22-ны өдөр ажлын хэсгийн гишүүд болон Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн "Эм" холбоо, Монголын эм хангамжийн байгууллагын холбоо, Монголын эм хангамжийн шинэчлэл холбоог тус тус оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тус хэлэлцүүлгээс гарсан санал, хурлын тэмдэглэлийг ЭЭХХЗГ-аас 2026.04.28-ны өдрийн 01/558 дугаар бичгээр ЭМЯ-ны Эрүүл мэндийн даатгалын бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн.
	62		47.9. Эм, эмнэлгийн хэрэгслийн үнийг гадаад, дотоодын жишиг үнэ, үнийн ил тод байдлыг хангах, хэлцэл хийх, эрүүл мэндийн технологийн үнэлгээний арга ашиглах журмыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	“Эм, эмнэлгийн хэрэгслийн үнийг гадаад, дотоодын жишиг үнэ, үнийн ил тод байдлыг хангах, хэлцэл хийх, эрүүл мэндийн технологийн үнэлгээний арга ашиглах журам”-ыг боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/429 дүгээр тушаалаар байгуулан ажиллаж байна. Журмын төсөлд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас санал авч, боловсронгуй болгож байна.
	66		58.2. Энэ хуулийн 50.1.4, 50.1.5, 50.1.6, 50.1.7, 50.1.8, 50.1.9, 50.1.10, 50.1.11, 50.1.15-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой төлбөр, хураамжийн хэмжээ, зардлын жишиг, зарцуулах журмыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалттай холбоотой төлбөр, хураамжийн хэмжээ, зардлын жишиг, зарцуулах журмын төслийг боловсруулж, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, төрийн бус байгуулагын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулсан. ЭМЯ-ны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлөөс санал авахаар 2026 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 6/1872 дугаар албан бичгийг хүргүүлж, Эрүүл мэндийн яамны цахим хуудсанд https://moh.gov.mn/news/7534 байршуулан санал авч байна.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ				
	114		1.1.г. г/Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын чиг үүргийг тодорхой болгон, эрх зүйн чадамжийг дээшлүүлж, байр, санхүүжилтийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх;	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 50 дугаар зүйлд Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг дэлгэрэнгүй тусгаж, тус хуулийн 58 дугаар зүйлд санхүүжилтийн талаарх заалтыг нэмэлтээр оруулж эрх зүйн чадамж дээшилсэн. Энэ хуулийн 58 дугаар зүйлийн 58.1-58.3 дахь хэсэгт Эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний хяналт, зохицуулалтын санхүүжилт нь улсын төсөв, Эрүүл мэндийг дэмжих сан, олон улсын байгууллага,

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
				хандивлагч орнуудын хандив, тусламж, төлбөр, хураамж болон хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэх, энэ хуулийн 50.1.4, 50.1.5, 50.1.6, 50.1.7, 50.1.8, 50.1.9, 50.1.10, 50.1.11, 50.1.15-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой төлбөр, хураамжийн хэмжээ, зардлын жишиг, зарцуулах журмыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлах, энэ хуулийн 58.2-т заасан төлбөр, хураамжийг энэ хуулийн 50.1-д заасан эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний хяналт, зохицуулалтын үйл ажиллагаанд зарцуулах зохицуулалт тус тус туссан. “ЭЭХХЗГ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг Эрүүл мэндийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/472 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. ЗГ-ын 2026 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 34 дүгээр хуралдааны тэмдэглэлээр БЗД-ийн 13-р хороо, 14-р хооолол Энхтайван өргөн чөлөө 54/6 хаягт байрлах Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн 3 дугаар байр руу 2026 оны 9 дүгээр сард нүүлгэн шилжихийг даалгасан бөгөөд ЭЭХХЗГ-ын байрны асуудлыг шийдвэрлэсэн.
	119		1.5. 5/бүртгэлийн зааврааc зөрүүтэй, чанаргүй болон хадгалалтын хугацаа дууссан, горим алдагдсан эм, эмийн бүтээгдэхүүний устгалын бүртгэлийг цахимжуулах арга хэмжээг авах;	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын нэгдсэн систем /**pmd.hdc.gov.mn**/ -ийн хөгжүүлэлт хийж тусгай зөвшөөрлийн чиглэл нэмэх, импортын мэдүүлэг, эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэлийн модулийн хөгжүүлэлт хийгдэж дуусч, системийг туршилтаар 2026.08.20-ны өдрөөс эхлэж ашигласан байна. Тус систем ажиллах серверийг Үндэсний дата төв УТҮГ-тай гэрээ байгуулан үүлэн сервер авсан. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс дэд домэйн /pmd.hdc.gov.mn/ хаяг үүсгэж системийг ажиллуулж байна. SSL сертификатын тохируулга хийж аюулгүй байдлыг хангасан. Эрүүл мэндийн байгууллага, эм хангамжийн байгууллагуудын бүртгэлийн зааврааc зөрүүтэй, чанаргүй болон хадгалалтын хугацаа дууссан, горим алдагдсан эм, эмийн бүтээгдэхүүний устгалын мэдээллийг Элемент ХХК, Элемент медикал ХХК-тай зөвшилцөж “Цахим мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэхээр болсон. Цахим санд тухайн аж нэгжийн талаар мэдээлэл болон эм, эмийн бүтээгдэхүүний 16 төрлийн мэдээллийг оруулж байна. Энэхүү нэгдсэн систем дээрх устгалын мэдээг тус

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
				2 байгууллагад хэрэглэгчийн эрх үүсгэн өгч, хамтран ажиллахаар тохиролцсон.
	121		1.7. 7/эмийн цувралын чанарыг санамсаргүй түүврийн аргаар хянах тогтолцоог нэвтрүүлэх;	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын нэгдсэн систем /**pmd.hdc.gov.mn**/-ийн хөгжүүлэлт хийж тусгай зөвшөөрлийн чиглэл нэмэх, импортын мэдүүлэг, эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэлийн модулийн хөгжүүлэлт хийгдэж дуусан, системийг туршилтаар 2026.08.20-ны өдрөөс эхлэн ашиглаж байна. Тус систем ажиллах серверийг Үндэсний дата төв УТҮГ- тай гэрээ байгуулан үүлэн сервер авсан. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс дэд домэйн /pmd.hdc.gov.mn/ хаяг үүсгэж системийг ажиллуулж байна. SSL сертификатын тохируулга хийж аюулгүй байдлыг хангасан. Эмийн цувралын чанарыг санамсаргүй түүврийн аргаар хянахаар “Цахим мэдээллийн нэгдсэн сан”-д дараах мэдээллийг систем хооронд мэдээлэл солилцож бүрдүүлэхээр болсон. Үүнд: 1.Ханган нийлүүлэх байгууллагуудын байршил авах сервис 2. Байгууллагын зарлагын мэдээлэл авах сервис (аж нэгжийн талаар мэдээлэл болон эм, эмийн бүтээгдэхүүний 22 төрлийн мэдээлэл) Дээрх хөгжүүлэлтийн хүрээнд Эм, эмнэлгийн хэрэгслийн хамгийн бага хэмжих нэгж, түүний суурь үнэ, бөөний үнэ, жижиглэнгийн үнийг тухай бүр байршуулах ажлын хүрээнд эм хангамжийн байгууллагуудаас мэдээллийг авч, нэгдсэн системд холбох ажлыг хийж байна. Эмийн ПОС-ын программ хөгжүүлэгч 11 байгууллагаас 5 байгууллага холбогдож, 338 эмийн сангийн байршилд худалдаалагдаж буй 4000 гаруй эм (давхардсан тоогоор) -ийн мэдээлэл ирж системийн хувьд цувралаар мөшгих тогтолцоо үүсч байна.
	122		1.8. 8/иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд эмийн зохистой хэрэглээний талаар сургалт, сурталчилгаа явуулах;	Салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд 2026.05.08-ны өдөр анагаах ухаан, мал эмнэлэг, байгаль орчин, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 18 байгууллагын (Ерөнхийлөгчийн Тамгын газар, НҮБ-ын ХХААБ, ҮШУТсан, МЭЕГ, ХӨСҮТ, НЭМҮТ, ЗӨСҮТ, АШУҮИС, Ач АУИС, ХААИС, УМЭАЦТЛ, УХЭШХ, Биологийн хүрээлэн, ХАБҮЛЛ, “Юргана индастри” ХХК, “Гарааны праймер” ХХК) 80 гаруй эрдэмтэн, судлаачид, мэргэжилтнүүд оролцсон арга хэмжээнд Бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээний талаар танилцуулга хийсэн.

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
				-Эм зүйн мэргэжлээр төгсөгчдийн холбоо, АШУҮИС-тай хамтран 2026.06.10-ны өдөр зохион байгуулсан “Эмийн аюулгүй байдлыг хангахад эмнэлгийн мэргэжилтний оролцоог нэмэгдүүлэх нь” сургалтад Эмийн зохистой хэрэглээ сэдвээр танилцуулга хийсэн. Иргэд, эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтнүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд ЭЭХХЗГ, НЭМҮТ 2026 оны 9 дүгээр сарын 14-17-ны өдрүүдэд нийслэл болон орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын 15 мэргэжилтнийг үндэсний сургагч багшаар бэлтгэх ажлыг хамтран хэрэгжүүлж байна. Тус сургалтад эмийн жор бичилтийн стандарт, цахим жор, эмийн зохистой хэрэглээтэй холбогдох хууль, журмын талаар илтгэл тавьж, асуусан асуултад хариулт өгсөн.
	123		1.9. 9/хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр холбогдох төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагааг уялдуулж, хугацаатай үүрэг даалгавар өгөх;	"Эмийн зохистой хэрэглээ", "Антибиотик эмийн зохистой хэрэглээ", "Бичил биетний тэсвэржилт"-ийн талаарх Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт тусгуулах сэдэв, агуулгын саналыг 2026.02.11-ний өдрийн 01/207 дугаар албан бичгээр Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнд хүргүүлсэн. Тус газраас 2026.03.09-ний өдрийн 01/39 дугаар албан бичгээр цаашид шинэчлэн боловсруулах суурь болон бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрт тодорхой агуулгыг тусгаж хамтран ажиллах боломжтой талаар хариу ирүүлсэн. Албан бичгийн дагуу Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн хариуцсан мэргэжилтэнтэй 2026.06.11-ний өдөр уулзалт хийж, ахлах ангийн сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг байгуулагдахад санал авахаар тохиролцсон. Мөн тус хүрээлэнгийн саналын дагуу 2026.06.12-ны өдөр 1 дүгээр ангийн сурагчдын дасгал ажлын дэвтэр боловсруулах ажлын хэсгийн багштай уулзаж эм, чихрийн ялгааг таниулах, эмийг зөвхөн эцэг эх, багш, эмчийн зааврааар хэрэглэх зэрэг саналуудыг уламжилсан бөгөөд дасгал ажлын дэвтрийг боловсруулах ажил эхлэх үед санал авахаар тохиролцсон. Энэхүү ажил нь 2026 онд ерөнхий боловсролын сургуулиудын 1 дүгээр ангийн сурагчдын сурах бичиг хэвлэх ажил удаашралтай байгаатай холбогдуулан түр хугацаанд зогссон байна. Дасгал ажлын дэвтэр боловсруулах ажлын хэсэг одоогоор байгуулагдаагүй байна.
	124		1.10. 10/Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эм, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг олон нийтийн цахим	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.9-д “эмийг цахим орчин дахь нийгмийн сүлжээгээр сурталчлахыг хориглосон”, 26.5.10-д “эрүүл мэндийн нэмэлт

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
			сүлжээгээр сурталчлахыг хориглох, сурталчилсан тохиолдолд хариуцлага хүлээлгэх талаар төрийн байгууллагуудын уялдааг хангах;	бүтээгдэхүүнийг өвчнийг оношлох, эмчлэх үйлдэлтэй гэж олон нийтийг төөрөгдөлд оруулсан байдлаар сурталчлахыг хориглосон" заалт тус оруулснаар бүртгэгдээгүй эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг олон нийтийн цахим сүлжээгээр сурталчилахыг хориглох эрх зүйн орчны бүрдсэн. Олон нийтийн мэдээлэх хэрэгслээр сурталчилж буй эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, үйлчилгээ нь Зар сурталчилгааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг Монополын эсрэг газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас ажлын хэсэг, хяналт шалгалтын удирдамжийг 2026.03.09-ний өдөр батлсан. Монополын эсрэг газрын 2026.03.09-ний өдрийн хяналт, шалгалтын удирдамжийн дагуу 2026.03.09-ний өдрөөс 2026.05.09-ний өдөр хүртэлх хугацаанд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, үйлчилгээ нь Зар сурталчилгааны тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан. Мөн шалгалтад хамрагдсан аж нэгжийн 50 ажилтанд 2026.06.26-ны өдөр 2 удаагийн сургалтыг орсон. Эмийн зар сурталчилгааны хяналт шалгалтын дүнг үндэслэн зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх, зөрчил давтан гаргахгүй байх талаарх зөвлөмжийг 200.400 гишүүнтэй 6 мэргэжлийн нийгэмлэг, холбоодод зөвлөмж хүргүүлсэн. Цахим орчин дахь нийгмийн сүлжээнд зөвшөөрөлгүй, хууль бус бүртгэлгүй эм, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг илрүүлэх холбогдох хууль тогтоомжийг таниулан, сурталчилсан иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор 2026 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд тандалтыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын батлсан удирдамжийн дагуу гүйцэтгэж байна.
	125		1.11. 11/Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны санал, дүгнэлтийг хэрэгжүүлэх;	Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос 15 санал, дүгнэлт өгсөнөөс холбогдох заалтуудыг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгасан. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга УИХ-аар 2024 оны 06 дугаар сард батлагдаж, 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
	127		2. Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлд хийсэн хяналт шалгалтын явцад төрийн байгууллага дахь эм хангамжийн байгууллагын хамаарал, эм хангамжийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд үүссэн байж болзошгүй хувийн ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг холбогдох хуулийн дагуу шалган, иргэд олон нийтэд нээлттэй мэдээлэхийг Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-т, хяналт шалгалтаар илэрсэн гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг холбогдох хуулийн дагуу шалгаж, шийдвэрлүүлэхийг Монгол Улсын ерөнхий прокурор Б.Жаргалсайханд тус тус зөвлөсүгэй.	Энэхүү заалтаар Авлигатай тэмцэх газар болон Монгол Улсын ерөнхий прокурорт үүрэг даалгавр өгөгдсөн ба Эрүүл мэндийн яаманд хамааралгүй заалт байна.
	133		1.5. 5/үндэсний түвшинд био-эквивалент чанарын судалгаа хийх чадавх бүрдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.7, 15.1.11, 15.1.13-т заасан байгууллагыг лабораторийн тоног төхөөрөмж, урвалж бодисоор хангах, хүний нөөцийг сургаж бэлтгэхэд шаардагдах санхүүжилтийг улсын төсөвт жил бүр тусгаж, 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор бүрэн шийдвэрлэсэн байх;	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.14-д “Био-эквивалент чанар шаарддаг ерөнхий нэршлийн эмийн тухайд био-эквивалент судалгаа хийгдсэн байна” гэж заасан. Мөн “Эм, эмийн үйлчлэгч бодис, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг бүртгэх журам”-ыг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/206 дугаар тушаалаар баталж, тус журмын 3.1.9-д “Ерөнхий нэршлийн эм нь биоэквивалент чанарын судалгаагаар биоэквивалент болох нь тогтоогдсон байх” зохицуулалтыг тусгасан. Эмийн био-эквивалент судалгаа хийх хүний нөөцийг чадавхжуулж, тус судалгааг хийж эхлүүлэхээр “Эрүүл мэндийг дэмжих жил 2027” төлөвлөгөөнд тусгаж, 2027 оны төсөвт тусгуулан хэрэгжүүлэхээр саналыг СЭЗБХГ-т хүргүүлсэн байна.
	134		1.6. 6/Хууль тогтоомжийн тухай хуулийн 46.3-т заасны дагуу Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг нийт хүн ам, эрүүл мэндийн ажилтнуудад сурталчлан	Эм зүйн салбарын 100 жилийн хөгжлийн үр дүн, туршлага-хэтийн чиг хандлага” эрдэм шинжилгээний бага хурал 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдөр болж, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн хэрэгжилт, цаашид хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээний талаар хэлэлцсэн. https://moh.gov.mn/news/7485

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
			таниулах, түүнд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх.	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас 2026 оны байгууллагын үйл ажиллагааны төсвийн саналд 400 орчим сая төгрөгний ажлыг төлөвлөн бараа үйлчилгээний зардалд тусган саналыг хүргүүлсэн боловч 40 сая төгрөг бараа үйлчилгээний зардал батлагдсан боловч санхүүжилт байхгүй улмаас гүйцэтгэх боломжгүй байна.
45	137	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 38 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай 2024-08-30 Дугаар 2024_30_1	1.1. 1/Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж итгэлцлийн зохистой дадлыг хэрэгжүүлэх хүрээнд эмийн зохицуулалтын үнэлгээгээр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүлээн зөвшөөрсөн эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах;	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар болон Бүгд Найрамдах Польш Улсын Эм, эмнэлгийн хэрэгсэл, биоцидын бүтээгдэхүүний бүртгэлийн газар хооронд “Хамтын ажиллагааны тунхаглал”-д 2026 оны 02 дугааар сарын 05-ны өдөр гарын үсэг зурсан. Тус ажлын хүрээнд уламжлалт эмийн үйлдвэрлэлийн асуудлаар зөвлөгөөн зохион байгуулж, Польш Улсын Эмийн бүртгэлийн агентлагийн төлөөлөл Монгол Улсад айлчлан, ЭЭХХЗГ, дотоодын уламжлалт эмийн үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцсан. БНТурк Улсын эмийн зохицуулалтын байгууллагатай эмийн бүртгэлийн эрх зүйн орчны талаар мэдээлэл солилцож байна. Итгэлцлийн зохистой дадлыг хэрэгжүүлэх хүрээнд эмийн зохицуулалтын үнэлгээгээр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүлээн зөвшөөрсөн эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагатай 2026 оны 3 дугаар улирлын байдлаар 110 нэрийн эмийг түргэвчилсэн бүртгэлээр бүртгэсэн.
53	151	Чиглэл өгөх тухай 2025-12-30 Дугаар 2025 №124	1.6. 6/эмийн зохицуулалтын төлөвшлийн түвшин өндөр улсуудаас чанартай эмийг бөөнөөр худалдан авч, ханган нийлүүлэлтийг нэмэгдүүлэх замаар эмийн үнийг бууруулах, зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарласан зохицуулалтыг хялбаршуулж, үнийн өсөлтөд хяналт тавих;	Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд түгээмэл хэрэглэгддэг төрөөс төлбөрийг нь хариуцах удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардагдах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний эм, Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр олгох эмийн судалгаа хийж, олон улсын байгууллалуудаас санал авч, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр олон улсын байгууллагатай Эрүүл мэндийн сайд харилцан ойлголцлын санамж бичиг зурж, гемофиллийн 4 нэрийн факторыг НҮБХХ олон улсын байгууллагаар дамжуулан худалдан авсан. Мөн ЭЭХХЗГ төрөөс төлбөрийг нь хариуцах эмийн жагсаалт болон эрүүл мэндийн байгууллагуудын саналд үндэслэн төсөвт өндөр дүн эзэлдэг, тасалдах эрсдэлтэй, эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай 179 нэрийн эмийн судалгааг олон улсын байгууллагуудад хүргүүлж, үнийн санал авч байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.15 дахь хэсэгт заасны дагуу Санхүүгийн мэдээллийн технологийн

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
				төвтэй хамтран e-barimt гар утасны аппликейшны Эрүүл мэнд цэсэд нэмэлт хөгжүүлэлт хийж, эмийн үнийг иргэнд ил тод мэдээлэх em.hdc.gov.mn цахим системийг 2025 оны 10 дугаар сард хэрэглээнд нэвтрүүлсэн. Тус системд Монгол Улсад бүртгэлтэй нийт эмийн жагсаалтаас худалдаанд идэвхтэй борлуулагддаг 2,234 эм, 2,774 эмийн сангийн газарзүйн байршил бүхий мэдээллийг эмийн сан бүрээр и-баримтын системд хамгийн их борлуулалттай эмээр ил тод болж, иргэний нээлттэй болгосон. Уг системд 2026 оны 3 дугаар улирлын байдлаар 87,728 гаруй хандалт хийгдсэн байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.8 дахь хэсэгт заасны дагуу зайлшгүй шаардлагатай эмийн бөөний болон жижиглэнгийн үнийн нэмэгдэх хувь хэмжээний хязгаарын төслийг боловсруулж, холбогдох байгууллагаас санал авч байна.
УИХ-ЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ				
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ				
	225		1.14. Эмийн худалдаа, чанар, хадгалалт, эргэлтэд тавих хяналтыг чангатгах.	ЭЭХХЗГ-ын Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтын улсын байцаагч нар 2026 оны 3 дугаар улирлын байдлаар улсын хэмжээнд нийт 455 байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт, 125 байгууллагад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, 69 байгууллагад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, 70 өргөдөл, гомдол хүлээн авч, шийдвэрлэсэн байна. Хяналт шалгалтын хүрээнд Зөрчлийн тухай хуулийн хүрээнд хялбаршуулсан журмаар 60, зөрчлийн хэрэг нээн шийдвэрлэсэн 16, харьяаллын дагуу шилжүүлсэн 3, цагдаагийн байгууллагад 2 асуудлыг шилжүүлэн, дутагдлыг арилгуулах зорилгоор 90 байгууллагад 710 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Илэрсэн зөрчилд нийт 58 байгууллага, иргэнд 130 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан. Мөн үйл ажиллагааны 21, бүтээгдэхүүний 72 дүгнэлт гаргасан байна.
ҮАБЗ-ИЙН ЗӨВЛӨМЖ				
91	268	Эм вакцин, биобэлдмэ-лийн хангамж, нөөц-чанар тэдгээрийн	Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэл, зах зээл дэх чанар, аюулгүй байдлын тандалт судалгаа хийх, чанарын баталгаажуулалт, үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл, эм зүйн үйл ажиллагаанд тавих	Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэл, зах зээл дэх чанар, аюулгүй байдлын тандалт судалгаа хийх, чанарын баталгаажуулалт, үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл, эм зүйн үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналт, эмийн гаж нөлөөнд тавих хяналт, зар сурталчилгааны зөвшөөрөл, хяналтыг зохицуулалтын чиг үүргийг Засгийн газрын хэрэгжүүлэгч

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
		аюулгүй байдалд тавих хяналт 2013-01-08 Дугаар 2013_03/03	мэргэжлийн хяналт, эмийн гаж нөлөөнд тавих хяналт, зар сурталчилгааны зөвшөөрөл, хяналтыг төрийн нэрийн өмнөөс гүйцэтгэх бие даасан эмийн эсвэл эм, хүнсний зохицуулалтын асуудал эрхэлсэн нэгдсэн агентлагийг бусад улс орны жишгийн дагуу байгуулах;	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрыг Засгийн газрын 2020 оны 222 тогтоолоор байгуулж, 2021 оны 378 дугаар тогтоолоор эм биобэлдмэлийн хяналтын чиг үүргийг тус агентлагт нэгтгэсэн. Засгийн газрын 2025.08.20-ны өдрийн Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 52 дугаар тогтоолын дагуу 120 албан хаагчийн орон тооны хязгаартай баталсан. Мөн Эрүүл мэндийн сайдын 2025.12.19-ний өдрийн Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай А/472 дугаар тушаалын дагуу бүтэц орон тоо шинээр баталсан.
	269		2. Эмийн түгээлтийн шат бүрд эмийн үнийг хянах механизмыг бий болгох;	Импортын эмийг гаальд мэдүүлсэн үнээс эхлэн эцсийн хэрэглэгчийн гарт очих хүртэлх бүх шатанд үнэ, үнийн өсөлтийг ил тод болгох цахим хөгжүүлэлтийг Санхүүгийн мэдээллийн технологийн төв-Улсын төсөвт үйлдвэрийн газраар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, Гааль, татварын нэгдсэн цахим системтэй холбож, и-баримт гар утасны аппликейшны шинэ хувилбарт интеграци хийсэн. Ингэснээр иргэд Монгол Улсад бүртгэлтэй эмийн үнийг худалдаалагдаж буй эмийн сангийн байршлын хамт (эмийн олон улсын нэршил, худалдааны болон үйлдвэрлэгчийн нэр, бүртгэлийн дугаар, найрлага, дүрслэл, эмийн үйлдэл, хэрэглэх заавар, эсрэг заалт, гаж нөлөө гэх мэт) тодорхой мэдэх боломжийг бүрдүүлсэн. Газарзүйн байршлаар эмийн үнийг ил тод болгосноор эмийн үнийн өсөлтийг иргэд, олон нийт хянах болсон. Дээрх систем (https://em.hdc.gov.mn/)-д 2026 оны 01 дүгээр улирлын байдлаар 2,774 эмийн сангийн байршил, Монгол Улсад бүртгэлтэй нийт эмийн 50 гаруй хувь буюу 2,234 нэрийн эмийн үнийн мэдээллийг газарзүйн байршлаар ил тод байршуулсан. 2026 оны эхний хагас жилийн байдлаар уг системд 84,000 хандалт хийгдсэн байна. Эрүүл мэндийн сайдын 2026 оны А/33 дугаар тушаалаар “Эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн цахим мэдээллийн нэгдсэн санг ажиллуулах журам” боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, журмын төслийг боловсруулан ЭЭХХЗГ-аас санал авахаар хүргүүлсэн бөгөөд саналыг 2026.08.13-ны өдөр авсан.

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
				Эм холбоо, Эмийн сангийн холбоо болон ханган нийлүүлэх байгууллагуудтай 2026.05.29-ний өдөр уулзалт хийж “Цахим мэдээллийн нэгдсэн сан”-д дараах мэдээллийг систем хооронд 22 мэдээллийг солилцож бүрдүүлэхээр болсон. Мөн эмийн сангийн посын программ хөгжүүлэгч байгууллагуудтай систем хооронд мэдээлэл солилцох гарын авлагыг албан бичгээр хүргүүлэн системийн хөгжүүлэлт хийж байна. Дээрх хөгжүүлэлтийн хүрээнд эм, эмнэлгийн хэрэгслийн хамгийн бага хэмжих нэгж, түүний суурь үнэ, бөөний үнэ, жижиглэнгийн үнийг тухай бүр байршуулах ажлын хүрээнд эм хангамжийн байгууллагуудаас мэдээллийг авч, нэгдсэн системд холбох ажил эхлээд байна. Эмийн ПОС-ын программ хөгжүүлэгч 11 байгууллагаас 5 байгууллага холбогдож, 338 эмийн сангийн байршилд худалдаалагдаж буй 4000 гаруй эм (давхардсан тоогоор) -ийн мэдээлэл ирж системийн хувьд цувралаар мөшгих тогтолцоо үүсч байна.
	270		3. Бүсийн төвүүдэд болон эм, эмнэлгийн хэрэгсэл нэвтрүүлдэг хилийн боомтууд дээр эм, биобэлдмэлийн сорилын лаборатори байгуулах, шинжилгээний түргэвчилсэн арга нэвтрүүлж, хил гаалийн хяналтыг сайжруулах;	Эм, эмнэлгийн хэрэгслийн хилийн хяналтыг Гаалийн ерөнхий газар хэрэгжүүлдэг. ГЕГ-ын лаборатори нь бараааны ангилал, код тодорхойлох чиглэлтэй ажилладаг ба эм, эмнэлгийн хэрэгслийн дээжийг ЭЭХХЗГ-ын Эм, эмнэлгийн хэрэгслийн үндэсний лавлаа лабораторит шинжилүүлж байна.
	272		Үндэсний эм, вакцин, биобэлдмэлийн үйлдвэрлэлийг дэмжиж ЭМЯ-д үйлдвэрлэл хариуцсан нэгж бий болгох;	Эм, биологийн идэвхит бүтээгдэхүүний бүртгэл, зах зээл дэх чанар, аюулгүй байдлын тандалт судалгаа хийх, чанарын баталгаажуулалт, үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл, эм зүйн үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналт, эмийн гаж нөлөөнд тавих хяналт, зар сурталчилгааны зөвшөөрөл, хяналтыг зохицуулалтын чиг үүргийг Засгийн газрын хэрэгжүүлэгч Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрыг Засгийн газрын 2020 оны 222 тогтоолоор байгуулж, 2021 оны 378 дугаар тогтоолоор эм биобэлдмэлийн хяналтын чиг үүргийг тус агентлагт нэгтгэсэн. “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2025.08.20-ны өдрийн 52 дугаар тогтоолын дагуу 120 орон тооны хязгаартай баталсан. Эрүүл мэндийн сайдын 2025.12.19-ний өдрийн А/472 дугаар тушаалаар “ЭЭХХЗГ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг шинэчлэн баталсан.

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
				ЭЭХХЗГ нь үндэсний эм, вакцин, биобэлдмэлийн үйлдвэрлэлийг дэмжиж, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, эмийн зохицуулалтын чиглэлээр туршлага солилцох, 2 улсын эмийн салбарын байгууллага, үйлдвэрлэгчдийн хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд Бүгд Найрамдах Польш Улсын эмийн зохицуулалтын байгууллага болон эм үйлдвэрлэгч компанийн төлөөлөгчдийг оролцуулан эрдэм шинжилгээний хурал болон бизнес уулзалтыг 2026 оны 9 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уулзалтад Бүгд Найрамдах Польш Улсын Эм, эмнэлгийн хэрэгсэл, биоцид бүтээгдэхүүний бүртгэлийн газар (The Office for Registration of Medicinal Products, Medical Devices and Biocidal Products–URPL) болон Польшийн төрийн өмчит эм үйлдвэрлэгч TZF Polfa S.A. компанийн нийт 7 төлөөлөгч, дотоодын уламжлалт эм үйлдвэрлэгч 7 эмийн үйлдвэрийн төлөөллүүд оролцсон. Энэхүү уулзалт нь Монгол Улс, Бүгд Найрамдах Польш Улсын эмийн зохицуулалтын байгууллагууд болон эмийн үйлдвэрлэлийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан туршлага судлах, экспортыг нэмэгдүүлэх цаашдын хамтарсан үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход ач холбогдолтой уулзалт болсон.
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ				
	295		3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд бүх талын дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг Эрүүл мэндийн сайд 2026 оны 03 дугаар сарын 10-ны өдөр дахин баталж, ХЗДХЯ-д хүргүүлсэн. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэгт 1 удаа оролцож, хуулийн ажлын хэсэгт санал өгч ажилласан. Тус хуулийн шинэчилсэн найруулгын төсөл Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар хэлэлцэгдэж, УИХ-д өргөн барьсан. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх” Үндэсний хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 01/2999 дугаар албан бичгээр ХЗДХЯ-д хүргүүлсэн. ЭЭХХЗГ-ын Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтын улсын байцаагч нар 2026 оны 3 дугаар улилын байдлаар Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм импортлох, худалдах, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл бүхий 33 эм ханган нийлүүлэх байгууллагад урьдчилан

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
				сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтаар нийт 82 дутагдал илрүүлж, 29 дутагдлыг газар дээр нь арилгуулж, 15 байгууллагад нийт 61 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, 1 зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байна. Эм ханган нийлүүлэх байгууллагуудад нийлүүлсэн, худалдсан эмийн орлого, зарлага, зарцуулалт, хадгалалт, түгээлт, устгалын бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байсан. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудын 69 ажилтныг мэргэжил арга зүйгээр ханган ажилласан байна.
ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ				
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ				
134	364	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 3 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-06-25 Дугаар 2025_3	3.17.6.2. Эрхэлсэн салбар, хариуцсан чиг үүргийн хүрээнд тус чуулганы арга хэмжээнд зохих дэмжлэг үзүүлж, идэвхтэй, оролцоог бүрэн хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд;	Эм зүйн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2026 оны 03 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж, салбарын 120 гаруй удирдах ажилтнууд хамрагдаж, тулгамдсан асуудал, шийдлийг хэлэлцсэн.
142	389	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-10 Дугаар 2025_16		
	390			
	420			
	421		19.9.2. 2.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, холбогдох журмуудыг шуурхай баталж, хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэнд;	1. **Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн** хэрэгжилтийг хангах хүрээнд нийт 17 журам, жагсаалт, хязгаарыг батлахаас 2026 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилт дараах түвшинд байна. Үүнд: - Эрүүл мэндийн сайдын 5 тушаал, -Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 4 тушаал тус тус батлагдан мөрдөгдөж байна. - Боловсруулалтын шатанд 8 журам, жагсаалт, хязгаар байна Хуулийн холбогдох заалт тус бүрээр хэрэгжилтийг авч үзвэл:

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
				• Хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэгт заасан “Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн үйлчлэгч бодис, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг бүртгэх журам”-ыг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/206 дугаар тушаалаар баталж, мөрдүүлэн ажиллаж байна. • Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасан “Фармаковижилансийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2025 оны А/128 дугаар тушаалаар баталж, мөрдүүлэн ажиллаж байна. • Хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт заасан “Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт, тэдгээртэй холбогдох үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, экспортлох, хадгалах, устгах, түгээх, худалдах үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/408 дугаар тушаалаар баталж, мөрдүүлэн ажиллаж байна. • Хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт заасан “Эмийн эмчилгээний хороо болон бичил биетний эсрэг эмийн дэд хорооны ажиллах журам”-ыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2025 оны А/28 дугаар тушаалаар баталж, мөрдүүлэн ажиллаж байна. • Хуулийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсэгт заасан “Эм, эмнэлгийн хэрэгслийн импорт, экспортын мэдүүлэг олгох журам”-ыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2024 оны А/209 дүгээр тушаалаар баталж, мөрдүүлэн ажиллаж байна. • Хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсэгт заасан “Нэг эх үүсвэрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрөл, тоо хэмжээ”-г Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/398 дугаар тушаалаар баталж, мөрдүүлэн ажиллаж байна. • Хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсэгт заасан “Бүртгэлгүй, хуурамч, стандартын шаардлага хангаагүй эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний эргэлтээс сэргийлэх, илрүүлэх, шуурхай сэрэмжлүүлэх, эргүүлэн татах, устгах үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
				2025 оны А/130 дугаар тушаалаар баталж, мөрдүүлэн ажиллаж байна. • Хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт заасан “Эмийн зөвлөл, Эмнэлгийн хэрэгслийн зөвлөлийн бүрэлдэхүүн, тэдгээрийн ажиллах журам”-ыг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/34 дүгээр тушаалаар баталж, 2026 оны А/35 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулан мөрдүүлж байна. • Хуулийн 23 дугаар зүйлийн 23.10 дахь хэсэгт заасан “Эмийн эмнэлзүйн туршилтын үе шат, тавигдах шаардлага, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага, гэрээний загвар, хяналт тавих журам, лабораторийн оношилгооны хэрэгслийн туршилт, судалгаа хийх журам”-ыг боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/146 дугаар тушаалаар байгуулсан. Олон улсын зааврыг орчуулж, эмийн эмнэлзүйн туршилтын үе шат, тавигдах шаардлага, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага, гэрээний загвар, хяналт тавих журмын төслийг боловсруулж, санал авахаар яамны цахим хуудаст байршуулсан https://moh.gov.mn/news/7510. Лабораторийн оношилгооны хэрэгслийн туршилт судалгааны олон улсын стандартыг орчуулж, хянаж, стандартын төслийг журмын хэлбэрт оруулахаар ажлын хэсэг ажиллаж байна. • Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт заасан зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2026 оны 0: дугаар сарын 13-ны өдрийн А/176 дугаар тушаалаар баталж, Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. • Хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан “дагуу Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2026 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/136 дугаар тушаалаар “Эмнэлгийн хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилах журам” А/137 дугаар тушаалаар “Эмнэлгийн хэрэгслийн эрсдэлийн зэргээр ангилсан жагсаалт”-ыг тус тус баталж, “Эмнэлгийн хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилах журмыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн. • Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсэгт заасан “Лабораторийн оношилгооны хэрэгслийн хяналт, эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг шинжлэх, эмнэлгийн тоног төхөөрөмжид

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
				шалгалт, баталгаажуулалт, шалгалт тохируулга хийх журам, арга, аргачлал”-ыг боловсруулах ажлын хэсгийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2024 оны А/202 дугаар тушаалаар байгуулж, төслийг боловсруулж байна. • Хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт заасан “Гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагатай гадаад улсаас шууд болон дамжуулан худалдан авах эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн, биобэлдмэл, вакцины санхүүжилтийг зохицуулах журам”-ыг боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/101 дүгээр тушаалаар байгуулж, журмын төслийг боловсруулж байна. • Хуулийн 47 дугаар зүйлийн 47.8 дахь хэсэгт заасан “Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн бөөний болон жижиглэнгийн үнийн нэмэгдэх хувь хэмжээний дээд хязгаар”-ыг тогтоох журмын төслийг боловсруулж, мэргэжлийн холбоод болон эрүүл мэндийн байгууллагуудаас санал авч, 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээс гарсан саналыг холбогдох байгууллагуудтай хамтран хэлэлцэж, төслийг боловсронгуй болгож байна. • Хуулийн 47 дугаар зүйлийн 47.9 дэх хэсэгт заасан “Эм, эмнэлгийн хэрэгслийн үнийг гадаад, дотоодын жишиг үнэ, үнийн ил тод байдлыг хангах, хэлцэл хийх, эрүүл мэндийн технологийн үнэлгээний арга ашиглах журам”-ыг боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/429 дүгээр тушаалаар байгуулж, ажиллаж байна. • Хуулийн 47 дугаар зүйлийн 47.16 дахь хэсэгт заасан “Эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн цахим мэдээллийн нэгдсэн санг ажиллуулах журам”-ыг боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/33 дугаар тушаалаар байгуулж, ажиллаж байна. • Хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт заасан “Эмийн зөвлөл, Эмнэлгийн хэрэгслийн зөвлөлийн бүрэлдэхүүн, тэдгээрийн ажиллах журам”-ыг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/206 дугаар тушаалаар баталж, 2026 оны А/35 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулан мөрдүүлж байна.

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
				• Хуулийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсэгт заасан эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалттай холбоотой төлбөр, хураамжийн хэмжээ, зардлын жишиг, зарцуулах журмын төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудын оролцоотой хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлөөс санал авахаар 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 6/1872 дугаар албан бичгийг хүргүүлэн, санал авч байна. **2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуул**ийн хэрэгжилтийг хангах хүрээнд 6 журам, дүрмээс батлахаас 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 1 дүрэм батлагдаж, 4 журам, дүрэм боловсруулалтын шатанд, 1 журам батлуулах шатанд байна. Хуулийн холбогдох заалт тус бүрээр хэрэгжилтийг авч үзвэл: • Хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн хүрээнд нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг нэгтгэн удирдах, халдварт болон халдварт бус өвчний эрсдэлийг удирдах, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх зорилгоор Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 107 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан “Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний зөвлөл”-ийг 26 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан. • Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн хүрээнд Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 52 дугаар тогтоолоор “Өвчний хяналт, сэргийлэлтийн үндэсний төв”-ийг байгуулж, дүрмийг баталсан. Үүний дагуу төвийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/60 дугаар тушаалыг батлан хэрэгжүүлж байна. • Хуулийн 11 дүгээр 11.3 дахь хэсэгт заасан “Нийгмийн эрүүл мэндийн төвийн бүтэц, дүрэм”-ийг боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2026 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар байгуулсан. Бүтэц, дүрмийн төслийг 2026 оны 2 дугаар улиралд багтаан батлуулахаар ажиллаж байна. • Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх хэсэгт заасан “Нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сангийн ажиллах журам”-

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
				ыг боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/65 дугаар тушаалаар байгуулсан. Журмыг 2026 оны 2 дугаар улиралд багтаан Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, инновaци, харилцаа холбооны сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар ажиллаж байна. • Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь хэсэгт заасан “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллах журам”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг Улсын онцгой комиссын даргын 2025 оны 02 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Журмын төслийг холбогдох сайд нарын хамтарсан тушаалаар батлуулахад бэлэн болгосон бөгөөд мэргэжлийн хяналтын байгууллагын бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор батлуулах шатанд хүлээгдэж байна. • Хуулийн 15.3 дахь хэсэгт заасан “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд олон нийтийн оролцоог хангах, сайн дурын ажилтныг урамшуулах журам”-ыг боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/65 дугаар тушаалаар байгуулж, журмыг 2026 оны 2 дугаар улиралд багтаан батлуулахаар ажиллаж байна. Хуулийн 19.5 дахь хэсэгт заасан “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх арга, төлбөртэй тусламж, үйлчилгээний төрөл, орлого, хандив тусламжийг зарцуулах журам”-ыг боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/124 дүгээр тушаалаар байгуулж, журмын төслийг боловсруулсан. Одоогоор журмын төсөлд яамны удирдлагын түвшинд санал авах шатанд байна.
ЗАСГИЙН ГАЗРЫН АЛБАН ДААЛГАВАР				
166	467	Макро эдийн засгийн өсөлтийг хадгалж, өрхийн бодит орлогыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний	2. Албан даалгаврын хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эдийн засаг, хөгжлийн яаманд сар бүр хүргүүлэхийг Засгийн газрын гишүүдэд, биелэлтэд нь хяналт тавьж, явц, үр дүнг нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг,	Тус албан даалгаварт Эрүүл мэндийн яаманд хамааралтай 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд 99. Архаг өвчний эмийн худалдан авалтыг нэгдсэн тендерээр зохион байгуулах, жижиглэнгийн монопол байдлыг задлах; 100. Сумын эмнэлгүүдийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, хүний нөөцийг чадавхжуулах арга хэмжээг тусгасан байна. 99. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд эмнэлгийн тусламж, үйлчилгээнд тасалдал үүсэх

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
		тухай 2026-03-18 2026_04	хөгжлийн сайд Ж.Энхбаярт тус тус үүрэг болгосугай.	эрсдэлтэй, төрөөс төлбөрийг хариуцах эмийн судалгааг гаргаж, олон улсын байгууллагаас худалдан авахаар мэдээлэл солилцож, худалдан авалтыг хийхээр ажиллаж байна. Эрүүл мэндийн яам, Нэгдсэн үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийг 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан. Санамж бичгийн хүрээнд эхний удаад цусны бүлэгнэлтийн эмгэг (гемофили)-ийн эмчилгээнд улсын хэмжээнд хэрэглэх гемофилийн VIII, IX дүгээр факторыг худалдан авахаар бэлтгэл ажил хийгдэж байна. 100. Сумын эмнэлгүүдийн тоног төхөөрөмжийг шинэчлэх чиглэлээр Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээний хүрээнд 7.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 69 нэр төрлийн 831 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмжийн жагсаалт, техник үзүүлэлтийг Эрүүл мэндийн сайдын 2026 оны А/72 дугаар тушаалаар батлаж, худалдан авах ажиллагааны эрхийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. Худалдан авах ажиллагааг 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдөр зарласан ба 04 дүгээр сарын 07-ны өдөр нээлт болно.
167	468	Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2026-04-08 2026_05		
	469		3.2. Эм, эмнэлгийн хэрэгслийн импортын бүрдүүлэлтийг түргэвчилсэн горимоор шийдвэрлэх, хилийн нэвтрэх цэгийн хяналтыг сайжруулж, чанар, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэхийг Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, Гаалийн ерөнхий газар (П.Дэлгэрнаран)-т;	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд заасны дагуу Эм, эмнэлгийн хэрэгслийн импорт, экспортын мэдүүлэг олгох журмыг ЭЭХХЗГ-ын 2024 оны А/209 дүгээр тушаалаар батлуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6983 дугаарт бүртгүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2026 оны 3 дугаар улирлын байдлаар 374 аж ахуй нэгжид Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын нийт 6453 импортын мэдүүлгийг хянаж олгосон байна. Үүнд: Эм -2124, Эмнэлгийн хэрэглэгдэхүүн-3056, Лабораторийн оношилгооны хэрэгсэл-922, Төрийн хяналт дор нэвтрүүлэх бараа-161, Хандив, тусламж -113, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм-76-н мэдээллийг Гаалийн ерөнхий газарт тухай бүр хүргүүлсэн байна. Мөн Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-business.mn-ээр 6866 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.
	470		3.3. Эм, эмнэлгийн хэрэгслийн зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарласан зохицуулалтыг өөрчлөх, эмийн чанар,	Эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн өсөлтөөс сэргийлж, үнийн хяналтыг сайжруулах зорилгоор Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн бөөний болон жижиглэнгийн үнийн

Шийд-вэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан
			аюулгүй байдлын хяналтын тогтолцоог сайжруулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд Э.Батшугарт.	нэмэгдэх хувь хэмжээний дээд хязгаарыг боловсруулсан. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, мэргэжлийн холбоодод албан бичиг хүргүүлэн санал авч, холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан 2026.03.31-ний өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг тусган боловсронгуй болгож байна.